



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Улаанбаатар хотын дулаан хангамжийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд бий болсон нийт 526,143,421.26 (таван зуун хорин зургаан сая нэг зуун дөчин гурван мянга дөрвөн зуун хорин нэгэн төгрөг хорин зургаан мөнгө) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасан хөрөнгө, холбогдох өр төлбөрийг “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Улаанбаатар дулааны сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярсайхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө, өр төлбөрийг Сангийн яамтай тооцоо нийлэн, хүлээлцэх, тооцоо нийлэх ажлыг компанийн өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Н.ГАНБОЛД

132005210
18-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

"Улаанбаатар дулааны сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Гэрээний дүн /гүйцэтгэлээр/	Капиталжуулах дүн			Хөрөнгө бүртгэх дүн (төгрөг)
			Зээлийн хүү	Хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамж	ТХНэгжийн зардал	
1	Шуурхай удирдлагын төв, сургалтын ерөөний засварын ажил	72,870,068.00	3,190,455.47	619,958.93	2,914,802.72	79,595,285.12
2	Зөөврийн компьютер, хэвлэх төхөөрөмж, сургалтын төвд шаардлагатай тоног төхөөрөмж, оффисын тавилгын хамт	89,900,000.00	3,539,812.50	854,050.00	3,596,000.00	97,889,862.50
3	Насосны центрозка тохируулах багаж	62,300,000.00	2,894,354.17	562,430.56	2,492,000.00	68,248,784.73
4	Дулааны шугамын шахалтын тоног төхөөрөмж	192,900,848.70	5,626,274.75	1,963,837.81	7,716,033.95	208,206,995.21
5	Огтолгоон төхөөрөмж нийлүүлэх	65,909,090.91	3,062,026.52	595,012.63	2,636,363.64	72,202,493.70
	Нийт дүн	483,880,007.61	18,312,923.41	4,595,289.93	19,355,200.31	526,143,421.26
		(дөрвөн зуун наян гурван сая найман зуун наян мянга долоон төгрөг жаран нэгэн мөнгө)	(арван найман сая гурван зуун арван хоёр мянга есөн зуун хорин гурван төгрөг дөчин нэгэн мөнгө)	(дөрвөн сая таван зуун ерэн таван мянга хоёр зуун наян есөн төгрөг гурван мөнгө)	(арван есөн сая гурван зуун тавин таван мянга хоёр зуун төгрөг гучин нэгэн мөнгө)	(таван зуун хорин зургаан сая нэг зуун дөчин гурван мянга дөрвөн зуун хорин нэгэн төгрөг хорин зургаан мөнгө)